



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ
ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/14/СТА-ТӨҮГ

2018 ОН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/14/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер C.Оюунгэрэл

Утас: 261885

Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж

Утас: 261740

Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

“Ихモンгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал С.Тунгалаг

Утас: 70001778

Цахим хаяг: tungalag.s@imkaudit.mn

Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сожидмаа

Утас 70001778

Цахим хаяг: sojidmaa.s@imkaudit.mn

Аудитор Д.Буянравжих

Утас: 70001778

Цахим хаяг: buyanravjikh.d@imkaudit.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Залруулсан алдааны талаар.....	4
2.9.2	Зөвлөмжийн талаар.....	5
2.9.3	Зорилтот түвшний төлөвлөлтийн талаар.....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материалаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал	8
	Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар.....	9
	Асуудал 2: Эзэмшигчийн өмчийн талаар	10
	Асуудал 3: Биет бус хөрөнгийн талаар.....	11
	Асуудал 4: Санхүүгийн програм хангамжийн талаар.....	12
	Асуудал 5: Зорилтот түвшний төлөвлөлтийн талаар.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин.....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018. 02. 26 № 06/539
таний -ны № -т

“ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН
АЧИХ БАЙГУУЛАМЖ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ЫН 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохицтой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланда санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансух танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн зорилтот түвшний биелэлт, үндсэн хөрөнгийн элэгдэл, санхүүгийн програм хамгажийн талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайллагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлзээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайллагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын удирдлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дүгээр сарын 10-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 06-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 09-нд эцэслэн баталгаажуулж, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Ихモンгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитор Д.Буянравжих, аудиторын туслах Т.Оюун, гэрээт ажилтан Н.Болормаа, аудиторын туслах М.Батжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 26 дугаар албан бичгээр “Ихモンгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандaa Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “ Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлэн ажилладаг.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын эрхэм зорилго нь: Газрын тосны бүтээгдэхүүний импортын хоёр дахь эх үүсвэрийг бий болгох зорилтой байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Монгол Улсаас газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангахад оршино.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь БНХАУ-аас нарийн царигийн вагон цистернерээр нийлүүлэгдэж байгаа газрын тосны бүтээгдэхүүн (автобензин, дизель тулш)-ийг өргөн царигийн вагон цистернд шилжүүлэн ачих юм.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгур болголоо.

Аудитаар Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 13 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 41 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ны санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Виница” програм хангамжаар бэлтгэсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгэр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” гэж үзлээ.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын дотоод хяналт, хууль эрх зүй хариуцсан 1 ажилтан нь захирлын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар баталсан дотоод хяналт шалгалтын журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажилладаг. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас 2015, 2016 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлого, дотоод хяналт нь хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байна гэж дүгнэсэн. Санхүү төсөвтэй холбоотой 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 278 дугаар тогтоолоор 1,194.0 сая төгрөгийн орлого, 959.1 сая төгрөгийн зардалтай, 211.4 сая төгрөгийн цэвэр ашигтай, 23.5 сая төгрөгийн орлогын албан татвар төлөхөөр баталсан байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь тайлант онд 472.3 сая төгрөгийн нийт орлоготой, 777.1 сая төгрөгийн зардалтай, 302.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 0,2 сая төгрөгийн орлогын албан татвар төлсөн байна. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих, хадгалах үйлчилгээнээс 413.8 сая төгрөг, хүү тогруулийн 1.8 сая төгрөг, үнэ төлбөргүй авсан 55.1 сая төгрөгийн хөрөнгийн, 1.1 сая төгрөгийн шинжилгээний орлоготой ажиллажээ. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө дараах нэхцэл байдлаас шалтгаалан тасарсан байна.

Оросын Холбооны Улс, газрын тосны бүтээгдэхүүнийхээ үнийг удаа дараа бууруулсантай холбоотойгоор импортлогч байгууллагууд тус улсаас газрын тосны бүтээгдэхүүн авч, БНХАУ-аас импортолоо бүтээгдэхүүний хэмжээ эрс буурсан байна. Үүнд:

1. 2017 онд 114.0 мянган тн газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачихаас 29.8 мянган тн бүтээгдэхүүн шилжүүлэн ачсан;
2. Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтаар нийт 2.0 мянган тн бүтээгдэхүүн хадгалахаас 1.4 мянган тн бүтээгдэхүүний хадгалсан;
3. Тайлант онд нийт 11 нэр төрлийн 158.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөснөөс хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээгүйгээс 52.3 сая төгрөгийн 3 ажлыг (байр, камер авах, гар станц) гүйцэтгэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад, оруулах шаардлагатай 14 төрлийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 41 нарийчилсан горим, сорил гүйцэтгэв.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Залруулсан алдааны талаар

- Голомт банкнаас авсан болон төлсөн 40.0 сая төгрөгийн банкны зээлийг мөнгөн гүйлгээний тайланд, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр, санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд 1.9 сая төгрөгийн харилцах дансны хүүгийн орлогыг, үндсэн үйл ажиллагааны бусад орлогоор, санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайланд 3.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг ерөнхий удирдлагын зардлаар тус тус тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 5 дугаар бүлгийн 3 дахь заалтыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын тодруулга ба толилуулаг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Нийт 114,7 сая төгрөгийн хангамжийн материалыг агуулахад болон ашиглалтанд байгаа хөрөнгө гэж ангилж бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 6 дугаар хэсэг, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Худалдан авсан 8.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ, худалдан авалтад төлсөн 0.7 сая төгрөгийн нэмэгдсэн өргтийн албан татварыг капиталжуулаагүй, нэмэгдсэн өргтийн албан татварын буцаан авалтаар бүртгэсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасныг мөрдөөгүй байна.

- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөөгүй, ашиглагдаагүй хөрөнгө гэж нийт 34 нэр төрлийн 14,382.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд 1,013.7 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй, бүртгэж тайлагнаагүй байна. Үүнээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 3 нэр төрлийн 1,969.8 сая төгрөгийн (сайжруулсан шороон зам, төмөр зам, замын далан) хөрөнгөнд 48.4 сая төгрөгийн элэгдлийг байгуулаагүй байна.

Энэ нь НББОУС 16.50-д “Хөрөнгийн элэгдүүлэх өртөг нь ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилагдана” гэснийг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны А-4/2663 дугаар тогтоолоор 28.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал данснаас үндсэн хөрөнгөнд шилжүүлэх тухай тогтоолын хэрэгжилтийг шалгахад, үндсэн хөрөнгийн орлогын дэлгэрэнгүй бүртгэлд 2.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 103, 2017 оны 358 дугаар тогтоолоор 243.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа 11.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр үнэ төлбөргүй хүлээн авсан 61.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг бүртгэж, тайлагнаадаа 5.6 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг, бусад орлогоор бүртгэж, татварын байгууллагад тайлагнаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д “төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшуулал” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх батlamж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

- Харилцах дансны хүүгийн 1.9 сая төгрөгийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайллангийн бусад орлогоор тайлагнаасан байна.
- Байгууллагын суудлын авто машинд сэлбэг хэрэгсэл худалдан авахад төлсөн 0.1 сая төгрөгийн, камер худалдан авахад төлсөн 0.7 сая төгрөгийг, Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авалтаар бүртгэж, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг 0.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бodoх бүртгэлд залруулж тайлагнав.

2.9.2 Зөвлөмжийн талаар

- Үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,593.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өмнөх оны аудитаар урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнаасныг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 358 дугаар тогтоолыг үндэслэн эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаал, байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичигт үнэ төлбөргүй авсан хөрөнгийг орлогоор бүртгэхээр заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батlamж мэдэгдлийн хангахгүй байна.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 358 дугаар тогтоолыг үндэслэн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,593.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлснийг, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй байна.

Энэ нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д ”Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тайлант хугацаанд 2 ш 945.6 сая төгрөгийн ашиглаагүй (агуулахын автоматжуулалтын програм хангамж, Скада програм) биет бус хөрөнгөнд 94.6 сая төгрөгийн элэгдэл байгуулаагүй байна.

Энэ нь НББОУС 16.60-д “Аж ахуйн нэгж нь үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс хамаарч тохирох аргыг ашиглана” гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батlamж мэдэгдлийг хангахгүй байна.

- Санхүүгийн програм хангамж нь Windows 8, 10 системд ажилладаггүй, экセル програмд шилжүүлэхэд үсгийн фонт танигдахгүй, хэвлэхэд санхүүгийн тайлангууд зөрүүтэй татагдаж байна.

Энэ нь санхүүгийн тайлантуур 1-нээ зөв байх толилуулга ба тодруулга батlamж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

2.9.3 Зорилтот түвшний төлөвлөлтийн талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 278 дугаар тогтоолоор 28 орон тоотойгоор 1,194.0 сая төгрөгийн орлого, 959.1 төгрөгийн зардал, 158.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай, 23.5 сая төгрөгийн татвар төлж, 211.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр 472.4 сая төгрөгийн орлоготой, 771.1 сая төгрөгийн зардал гаргаж, 52.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 304.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрлэлийн газрын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах”, гэж заасныг мөрдөөгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зорилтот түвшний төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, судалгаа тооцоог бодитой хийх, эрсдэл үүссэн тохиолдолд үндэслэлийг гаргаж, холбогдох байгууллагаад танилцуулан төлөвлөгөөг бууруулж батлуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгөв.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь шатахууны импортын үйл ажиллагаанаас шууд хамааралтай байна.
- Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу үнэ төлбөргүй шилжиж ирсэн, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргаагүй 3,593.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнасныг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг үндэслэн эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн ангилал, элэгдэл тооцох болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийг бүртгэх аргыг дахин хянаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8,233.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс:

Нийт 231.0 сая төгрөгийн алдааг залруулж, 8,202.2 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах тухай 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 774.9 сая төгрөгийн 1 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 777.4 сая төгрөгийн 1 хувь буюу 7.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн Сангиин сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,593.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өмнөх оны аудитаар урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнасаныг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 358 дугаар тогтоолыг үндэслэн эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаал, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үнэ төлбөргүй авсан хөрөнгийг орлогоор бүртгэхээр заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Зөвлөмж

Үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлогыг цаашид хэрхэн бүртгэх асуудлыг эрх бүхий дээд байгууллагуудтай зөвшилцэн шийдвэрлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Орлого буруу илэрхийлэгдэх, байгууллагын эдийн засгийн үр дүнг бодитой илэрхийлэхгүй байх.

/ЭҮ, ТТ, ИБ, Х, ҮЗ /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Асуудал 2: Эзэмшигчийн өмчийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 358 дугаар тогтоолыг үндэслэн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,593.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийг нэмэгдүүлснийг, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлээгүй байна.

Энэ нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Хууль тогтоомжийн дагуу, өмчийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ, ТТ, ИБ, УХ, УЗ, /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Асуудал 3: Биет бус хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

Ажиглалт

Тайлант хугацаанд 2 ш 945.6 сая төгрөгийн ашиглаагүй (агуулахын автоматжуулалтын програм хангамж, Скада програм) биет бус хөрөнгөнд 94.6 сая төгрөгийн элэгдэл байгуулаагүй байна.

Энэ нь НББОУС 16.60-д “Аж ахуйн нэгж нь үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс хамаарч тохирох аргыг ашиглана” гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Ашиглагдахгүй хөрөнгийг ангилан бүртгэж, элэгдэл байгуулахгүй байх үндэслэлийг эрх бүхий байгууллагатай зөвшилцэн тогтоох, зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Зардал буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ, ТТ, ИБ, Х, ҮЗ /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг
үйлчлүүлэгчийн удирдлага,
санхүүгийн ажилтанд танилцуулсан
болно.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа хийсэн аудит

Асуудал 4: Санхүүгийн програм хангамжийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №4

Ажиглалт

Санхүүгийн програм хангамж нь Windows 8, 10 системд ажилладаггүй, экспел программд шилжүүлэхэд үсгийн фонд танигдахгүй, хэвлэхэд санхүүгийн тайлангууд зөрүүтэй татагдаж байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Зөвлөмж

Програм хангамжийг ашиглалтыг сайжруулах буюу хэрэгцээ шаардлагад нийцсэн, програм хангамж ашиглах .

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ, ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Асуудал 5: Зорилтот түвшний төлөвлөлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №5

Ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 278 дугаар тогтоолоор 28 орон тоотойгоор 1,194.0 сая төгрөгийн орлого, 959.1 төгрөгийн зардал, 158.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай, 23.5 сая төгрөгийн татвар төлж, 211.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр 472.4 сая төгрөгийн орлоготой, 771.1 сая төгрөгийн зардал гаргаж, 52.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 304.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрлэлийн газрын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах”, гэж заасныг мөрдөөгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж

Зорилтот түвшний төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, судалгаа тооцоог бодитой хийх, эрсдэл үүссэн тохиолдолд үндэслэлийг гаргаж, холбогдох байгууллагад танилцуулан төлөвлөгөөг бууруулж батлуулах арга хэмжээг авч ажиллах .

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ, ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	142,999,069.33	61,013,131.89
Татвар, НДШ-ийн авлага	311,029.53	2,706,617.85
Бусад авлага	-	140,883.35
Бараа материал	135,658,756.38	115,211,992.45
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,400,000.00	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	284,368,855.24	179,072,625.54
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	13,585,162,681.99	13,407,504,936.85
Биет бус хөрөнгө	973,647,528.95	972,814,312.12
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,558,810,210.94	14,380,319,248.97
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,843,179,066.18	14,559,391,874.51
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	-	166,200.00
Цалингийн өглөг	-	-
Татварын өглөг	-	5,484,512.80
НДШ-ийн өглөг	-	0.30
Урьдчилж орсон орлого	3,593,000,000.00	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,593,000,000.00	5,650,713.10
Урт хугацаат зээл	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн дүн	3,593,000,000.00	5,650,713.10
Өмч Хувийн	11,276,843,049.32	14,869,843,049.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	-	44,414,440.00
Хуримтлагдсан ашиг	(26,663,983.14)	(360,516,327.91)
Эздийн өмчийн дүн	11,250,179,066.18	14,553,741,161.41
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,843,179,066.18	14,559,391,874.51

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого	718,472,672.75	413,805,971.80
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг/алдагдал	718,472,672.75	413,805,971.80
Хүүгийн орлого	-	1,869,068.31
Бусад орлого	-	56,686,504.15
Ерөнхий ба удирдлагын зардал	655,286,628.27	592,485,677.40
Санхүүгийн зардал	-	3,771,923.75
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(178,684,191.29)
Бусад ашиг/алдагдал/	(2,340,365.92)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	60,845,678.56	(302,580,248.18)
Орлогын албан татвар	8,686,138.00	186,906.83
Татварын дараах ашиг/алдагдал	52,159,540.56	(302,767,155.01)

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	ҮХөр дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,242,009,716.00	-	(74,453,003.70)	11,167,556,712.30
Залруулсан үлдэгдэл	-	-	(4,370,520.00)	(4,370,520.0)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	52,159,540.56	52,159,540.56
Өмчид гарсан өөрчлөлт	34,833,333.32	-	-	34,833,333.3
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	11,276,843,049.32	-	(26,663,983.14)	11,250,179,066.18
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	44,414,440.00	-	44,414,440.00
Өмчид гарсан өөрчлөлт	3,593,000,000.00	-	-	3,593,000,000.00
НББ-ийн алдааны залруулга	-	-	(31,085,189.76)	(31,085,189.76)
Залруулсан үлдэгдэл	-	-	(57,749,172.90)	(57,749,172.90)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(302,767,155.01)	(302,767,155.01)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	14,869,843,049.32	44,414,440.00	(360,516,327.91)	14,553,741,161.41

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ЫН 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Мөнгөн орлогын дүн	815,861,978.54	469,059,441.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	790,319,940.00	456,268,969.00
Даатгалын нөхверөөс хүлээн авсан мөнгө	-	
Бусад мөнгөн орлого	25,542,038.54	12,790,472.00
Мөнгөн зарлагын дүн	(709,078,803.26)	(484,986,596.75)
Ажиллагчдад төлсөн	315,206,225.00	198,268,632.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,566,260.11	54,677,555.00
Бараа материал авахад төлсөн	-	11,820,598.00
Ашиглалтын зардалд төлсөн	64,228,300.00	48,159,041.00
Түвш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,634,080.00	24,670,198.00
Хүүний төлбөрт төлсөн	-	3,771,923.75
Татварын байгууллагад төлсөн	97,486,717.75	63,670,100.00
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,573,850.00	143,850.00
Бусад мөнгөн зарлага	124,383,370.40	79,804,699.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн	106,783,175.28	(15,927,155.75)
Мөнгөн орлогын дүн	-	1,869,068.31
Худалдсан хөрөнгө борлуулсны орлого		-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	1,869,068.31
Мөнгөн зарлагын дүн	(271,552,865.00)	(52,280,000.00)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	271,552,865.00	52,280,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(271,552,865.00)	(50,410,931.69)
Мөнгөн орлогын дүн	-	40,000,000.00
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	-	40,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	(4,370,520.00)	(55,647,850.00)
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас төлсөн мөнгө	-	40,000,000.00
Ногдол ашиг	4,370,520.00	15,647,850.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,370,520.00)	(15,647,850.00)
Валютын ханшны зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(169,140,209.72)	(81,985,937.44)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	312,139,279.05	142,999,069.33
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,999,069.33	61,013,131.89

ТОГЛОН АУДИТОРЫН БАЙРСУУЛАЛТ

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4.5 Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
<i>I. Орлого</i>				
Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	912.00	227.90	(684.10)	25.0%
Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	270.00	185.90	(84.10)	68.9%
Бусад орлого /харилцахын хүү, ковш трактор түрээсийн г.м/	12.00	3.00	(9.00)	25.0%
Хандивын орлого	-	55.50	55.50	-
Орлогын дүн	1,194.00	472.30	(721.70)	39.6%
<i>II. Үл ажиллагааны зардал</i>				
Цалин хөлс	416.40	225.90	(190.50)	54.3%
Шагнал урамшуулал	2.00	1.70	(0.30)	85.0%
НДШ	50.00	28.60	(21.40)	57.2%
Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	27.00	2.80	(24.20)	10.4%
Цахилгааны зардал	74.00	50.20	(23.80)	67.8%
Албан томилот, баярын арга хэмжээний зардал	10.90	4.90	(6.00)	45.0%
Бичиг хэргийн зардал	1.50	0.50	(1.00)	33.3%
Элэгдлийн зардал	207.00	170.20	(36.80)	82.2%
Шуудан холбооны зардал	6.70	1.30	(5.40)	19.4%
Шатахууны зардал	21.80	11.00	(10.80)	50.5%
Аж ахуйн хэрэгцээнд	8.10	1.00	(7.10)	12.3%
Авто сэлбэгийн зардал масло тосол	7.00	7.40	0.40	105.7%
ТХ-ийн татвар, агаарын бохирдол, даатгал	2.50	0.40	(2.10)	16.0%
Зам арчлалтын төлбөр	38.00	28.50	(9.50)	75.0%
Үндсэн хөрөнгийн даатгал	30.00	-	(30.00)	0.0%
Банкны үйлчилгээний хөлс	0.02	0.02	-	100.0%
Банк хоорондын бэлэн бус гүйлгээний шимтгэл	0.05	0.02	(0.03)	40.0%
Газрын төлбөр	0.40	0.50	0.10	125.0%
Усны төлбөр	0.01	-	(0.01)	0.0%
Гал хөдөлмөр хамгааллын зардал	4.00	1.30	(2.70)	32.5%
Хэмжүүр хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын зардал	2.50	0.50	(2.00)	20.0%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	5.60	9.40	3.80	167.9%
Аудитын зардал	8.00	6.50	(1.50)	81.3%
Сургалтын зардал	4.00	0.20	(3.80)	5.0%
Зээлийн хүүгийн зардал	-	3.77	3.77	-
Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	6.00	0.60	(5.40)	10.0%
Лабораторийн итгэмгэмжлэл авахад шаардагдаа зардал	2.10	1.80	(0.30)	85.7%
Харуул хамгаалалтын зардал	-	25.10	25.10	-
Хөдөлмөрийн чадвар түр алдсан болон дотоод журмын дагуу олгогдох бусад тэтгэмжүүд	2.00	0.90	(1.10)	45.0%
Бусад зардал /Үл ажиллагаа явуулах явцад гарч ирэх зардал/	12.00	11.23	(0.77)	93.6%
Магадлашгүй зардал 1 %	9.50	-	(9.50)	0.0%
Үндсэн хөрөнгө балансаас хассаны алдагдал	-	178.70	178.70	-
Зардлын нийт дүн	959.08	774.94	(184.14)	80.8% ГАГА

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ЫН 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

4.6 Аудит хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан
Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын нэр	Х/нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Байгууламжийн гэрэлтүүлгийн шон будах, шонгийн доторх цахилгааны утас сольж хийх	сая/төг	4.0	-	(4.00)
Вагонэстекад будах шугам будах	сая/төг	2.0	-	(2.00)
Царцах, булингартах температур тодорхойлох багаж авах /лаборатори/	сая/төг	30.0	-	(30.00)
Спектрум түү багажны кувет /лаборатори/	сая/төг	5.0	-	(5.00)
Гражийн цахилгаан, халаалт татах	сая/төг	2.5	-	(2.50)
Байр /1-2 өрөө орон сууц/	сая/төг	44.0	44.0	-
Байгууламжийн өргөтгелийн ажлын зураг зуруулах	сая/төг	16.0	-	(16.00)
Газар доорх шавхалтын худаг өргөтөж хаалт тавих	сая/төг	21.0	-	(21.00)
Камерийн системийг шинэчлэх дэлгэц авах, камер авах	сая/төг	8.0	8.0	-
Шатахууны бага оврийн насос	сая/төг	4.0	-	(4.00)
Олон талт барилгын дээвэр засварлах	сая/төг	22.0	-	(22.00)
Гар станц	сая/төг	-	0.3	0.30
Нийт		158.5	52.3	(106.50)